КОРОНА-19 ХАЛДВАРЫН ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРСЭН ХҮҮХДИЙН МӨРДӨХ ЗААВАР

▣ Зааварчилгаанд хамрагдах хүүхэд

• Өөрийн оношлогооны хариугаар халдварын шинж тэмдэг илэрч **сургуульдаа явалгүй гэртээ байгаа үед**

• Тусгаарлаж эмчлэх газар(эмнэлэг)-т **шинжилгээ хийлгээд гэртээ харих үед**

▣ Мөрдөх журам

<Гэртээ харихдаа мөрдөх журам>

• Маск(KF94, KF80, бусад төрлийн маскнууд) зүүж, хүмүүстэй хүрэлцэхээс аль болох зайлсхийнэ.

• Тусгаарлаж эмчлэх газар(эмнэлэг)-т шинжилгээ хийлгээд гэртээ харих үед **өөр газар(PC тоглоомын газар, Пёныи-жом(24 цагийн дэлгүүр), биллъярд, кароке, кафе шоп зэрэг)-аар огт орж болохгүй** шууд гэр лүүгээ явна.

• Гэртээ харихдаа нийтийн тээврийн хэрэгслээр явахгүй.

(Жич, Гэр нь хол байдаг бөгөөд харих унаагүй зэрэг аргагүй нөхцөлд маск зүүж сууна)

< Гэрт мөрдөх журам>

• **Гадаа гарахгүй.**

• **Гэртээ байх хугацаанд дараах журмыг мөрдөнө.**

- Биеийнхээ байдлыг өдөрт тогтмол 2 удаа шалгах
  * Халдварын шинж тэмдэг илааршихгүй, хүндэрсэн үед сургууль болон 1339 дугаарын утсаар зөвлөгөө авч, өгсөн зааврын дагуу арга хэмжээ авна.
- Аль болох ганцаараа ашиглах боломжтой өрөөнд байрлах
- Өрөөний хаалгыг хаагаад цонхоо байнга онгойлгож агааржуулах
- Угаалтуур, суултуурыг ганцаараа ашиглах боломжтой өрөө ашиглах
  * Дундаа ашиглаж байгаа суултуурыг ариутгалын бодис(ариутгалын бодис бүхий салфетик, ахуйн зориулалтын белизна, ракс зэрэг)-оор угааж цэвэрлэсний дараа өөр хүнд хэрэглүүлэх
- Аль болох хувийн алчуур, аяга таваг, халбага сэрээ хэрэглэх

• **Хувийн ариун цэвэр сахих дүрмийг мөрдөнө.**

- Гараа савантай ус, ариутгалын бодисоор байнга угаах
- Маск зүүж, ханиалгахад баримтлах журмыг дагаж мөрдөх
  * Ханиалгахдаа ханцуйгаараа амаа таглах, ханиалгаж, найтаасны дараа даруй гараа угаах